ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 27 өдөр Дугаар 3/03 Сайншанд

Салбар зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
Орлогч дарга: Сумын Засаг дарга
Гишүүдэд: Засаг даргын орлогч
Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга
Засаг даргын Тамгын газрын дарга
Сайншанд багийн Засаг дарга
Хоолт багийн Засаг дарга
Бүйлсэн багийн Засаг дарга
Ерөнхий боловсролын сургуулийн захирал
Эрүүл мэндийн төвийн эрхлэгч
Соёлын төвийн эрхлэгч
Цэцэрлэгийн эрхлэгч
Дэмд-Од орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал
Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга
Засаг даргын Тамгын газрын Нийгмийн ажилтан
Засаг даргын Тамгын газрын байгаль хамгаалагч
Ерөнхий боловсролын сургуулийн Нийгмийн ажилтан
Говь гурван сайхан байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны Ирвэс хэсгийн ахлагч
Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн холбооны тэргүүн
Хэсгийн цагдаа
Нарийн бичгийн дарга: Цагдаагийн хэсгийн төлөөлөгч

4625013007

2. Сумын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан, ажлын тайланг иргэдийн Төлөөлөгчдийн хуралд жил бүр тайлагнаж ажиллахыг Салбар зөвлөлд үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд даалгасугай.

4. Зөвлөл шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Ч.ОГТБИШ